



Одоогийн Богд хааны ордон музей нь анх Монголын шашны тэргүүн ҮШ Богд Жавзандамба хутагтад зориулж 1893-1903 онд баригдсан бөгөөд 1926 онд Монголын анхны Үндэсний музей уг ордонд шилжин байрлаж байсан түүхтэй.

Музейн сан хөмрөгийн баяжилт

- 1928 он гэхэд 2117 зүйлийн 3000 –гаад үзмэртэй болсон байжээ.
- Одоогийн байдлаар тус музей нь /2012-2013 оны улсын тооллогын статистик мэдээ/ 4196 дэсийн 8626 ш үзмэртэй байна. Үүнээс үзмэр үзүүллэгт 465 дэсийн 1146ш үзмэр буюу нийт үзмэрийн 13,8% дэлгээстэй байж олон нийтийн хүртээл болж байна.

Үзмэрийн цуглуугын төрөл

- 1- цутгамал бурхад
- 2- уран зураг/танка/
- 3- зээгт наамал
- 4- төрөл бүрийн материалаар хийсэн бурхад/шавар, цаасан шуумал, модон сийлбэр/
- 5- бурхан номын хэрэглэл
- 6- хувцас өмсгөл
- 7- гэр ахуйн хэрэглэл
- 8-гоёл чимэглэлийн хэрэглэл
- 9-амьтдын чихмэл
- 10- цуглуулгын эд зүйлс
- 11- гэрэл зураг, туслах хэрэглэгдэхүүн
- 12- уран барилга байгууламж гэсэн бүтэцтэй.

1930- 1950-д он хүртэл музейн сан хөмрөгийн байрын талаар тодорхой баримт мэдээлэл алга байдаг бөгөөд музейн ахмад ажилтнуудаас сурвалжлахад одоогийн улаан сүм буюу хувцасны санд зарим зүйлийг авдарт хадгалдаг байсан гэх мэдээ бий.



- Одоогийн байдлаар Богд Хааны Ордон Музей нь Үндсэн, Танка зургийн, Үнэтийн гэсэн 3 сан хөмрөгтэй. Мөн 4 өрөө бүхий шинэ сан хөмрөгийн байртай.

Сан хөмрөгийн барилга

- 1950-д оны үед музейн хойд талын талбайд гаражийн зориулалтаар баригдсан тоосгон барилга руу сан хөмрөгийг нүүлгэж музейн ажилтнууд субботникийн журмаар үзмэр байрлуулах модон тавиур зэргийг өөрсдөө хийж байсан бөгөөд эдгээрийг сан хөмрөгт одоо ч хэрэглэглэсээр байна.

Богд хааны ордон музей

Үндсэн сан хөмрөг



- *Уг барилга нь гадуураа шавардлага бүхий тоосгон бүтэцтэй. 1 давхар 3,20 м өндөртэй, 11м өргөнтэй 40м нийт 440м² талбайтай .(сан хөмрөгийн байрны зураг) 1930-д онд зарим мэдээллээр 1950-д онд гаражийн зориулалтаар барьсан.*

- 80 гаруй жил олон тооны үзмэрийг хадгалж ирсэн. Дотор нь 1960-д оны үед ажиллаж байсан музейн ажилтнуудын субботникийн журмаар хийсэн үзмэр байрлуулах модон тавиуруудтай. Эдгээрийг сан хөмрөгт одоо ч хэрэглэглэсээр байна. Энд голдуу том оврын 323 дэсийн 1794ш үзмэрүүд хадгалагддаг.

Богд хааны ордон музей

Үнэтийн сан хөмрөг



- Үнэтийн сан хөмрөгийн байр юм. Үнэтийн сан хөмрөгт үзмэр хадгалах шүүгээ, сейф-иш, хувцасны 7 хайрцагт хадгалагдаж байдаг. Одоогийн байдлаар үзмэр хадгалах хамгийн боломжийн байр нь энэ тул энэ сан хөмрөгт цутгамал бурхад, модон сийлбэр, цаасан шуумал, өмсгөл хувцас, чулуун сийлбэр зэрэг олон төрлийн бүтэцтэй үзмэрүүдийг төрөлжүүлэн хадгалдаг.

Богд хааны ордон музей

Танка зургийн сан хөмрөг



- Танка зургийн сан хөрөг нь Үндсэн сан хөмрөгийн байрны хойд хэсэгт байрладаг бөгөөд энд танка зураг, бар зураг ,зээгт наамлын бүтээлүүд болон бусад зөөлөн эдлэлүүд нийт 2453 ш үзмэр, том оврын болон бусад төрлийн 108 дэсийн 531ш үзмэр хадгалагддаг.

Сан хөмрөгийн шинэ барилга

- -Богд хааны ордон музейн сан хөмрөгийн шинэ барилгыг 2006 онд ЗГ-н 269-р тогтоол гарсан.2010 онд БСШУ яамнаас зарласан тендерт шалгарсан “Цамхаг” констракшн барьсан, тоног төхөөрөмжийг “Анун” ХХК нийлүүлсэн.



ЗӨӨЛӨН ЭДЛЭЛИЙН ГЭМТЭЛ, ШАЛТГААН



Сан хөмрөг

Дулаан ,чийгшил, гэрэлтүүлгийн заалтыг мөрдөж ажиллах горимын үзүүлэлтүүд

Материал ,төрөл зүйл	Дулаан (°С)	Чийгшил (%)	Гэрэлтүүлэг (люкс)
Металл	+18 – +20	35-с50 хүртэл	200-с доош
Шил,керамик,шаазан	+12 – +20	55–65	200-с доош
Чулуу, чулуун эдлэл	+15 – +18	50–55	200-с доош
Мод, модон эдлэл	+15 – +18	50–60	50-с доош
Даавуун эдлэл	+15 – +18	55–65	50-с доош
Арьс,илэг,сарьс,ангийн үс	+16 – +18	50–60	50-с доош
Яс, эвэр, эдгээрээр хийсэн эд зүйлс	+14 – +15	55–60	150-с доош
Цаас,цаасан эдлэл	+17 – +19	50–55	50-с доош
Зураг/тосон/	+12 – +18	60–70	150-с доош
Хар цагаан гэрэл зураг	+12	40–50	50-с доош
Өнгөт гэрэл зураг	+5	40–50	50-с доош
Археологийн олдвор	+15-+18	30-60	50-с доош

Дулаан чийгийн хэт хэлбэлзэл

Гэмтсэн байдал



Цэвэрлэгээний дараа



Үзмэрийн хадгалалт 1994 он

Үзмэрийн байдал

Энгийн аргаар цэвэрлэж
байгаа байдал



Гэрэлтүүлгийн горим алдагдах



Өвлийн ордон

- үзмэрийг хоргонд байрлуулна.
- Өлгүүрт зөөлөвч хийсэн байх шаардлагатай.
- Цонхонд наалт, хөшиг
- Дулаан, чийгшил хэмжигч
- Хэт хуурайшилтай үед чийгшүүлэгч аппарат ажиллуулдаг

Үзмэр үзүүлэлэг

Битүү хоргонд
байрласан үзмэр



ил задгай байрласан
үзмэр



Үзмэр үзүүлэлэг

Зуны сүм

Зуны сүм



- Үзүүллэгийн үзмэрийг хоргонд байрлуулж гадны нөлөө болох тоос, тортог, шавьж болон бусад гэмтлээс хамгаалдаг
- Хоргонд байрлуулах боломжгүй үзмэрт тусгаарлах хаалт хийдэг
- Ил байрлуулсан үзмэрийг нарны хэт ягаан туяанаас хамгаалж хөшиг хаалт хийдэг

Өвлийн ордон



Механик арга хэмжээ

- Хадгалалтын стандартыг барихын тулд олон төрлийн механик үйл ажиллагаа явуулах шаардлага гардаг
- дулааны болон чийгшилийн горимыг тогтмолжуулах, агааржуулагч /кондиционер/ хэрэглэх, салхивч онгойлгох, сэнс үлээлгэх зэрэг.



Агаарын бохирдол, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

- Тоос шороо, хийн ялгаралт, утаа тортог болон агаарын бусад бохирдол нь музейн орчинг бохирдуулахын сацуу үзмэрийг бохирдуулж муутгадаг.
- Цэвэрлэгээ арчилгааг тогтмол хийж сан хөмрөгт хадгалагдаж байгаа үзмэрийг цуу ямбуу, шүлтгүй цаасаар ороох зэргээр механик хамгаалалтыг хийж байвал зохино.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

- Зөөлөн эдлэлийг мэрэгч, хортон шавьж зэрэг биологийн аюул эрсдэлээс хамгаалж мэргэжлийн байгууллагаар ариутгал устгал хийлгэдэг
- Тогтмол тандалт хийдэг / баригч, хавх гэх мэт /
- Үзмэрт тогтмол үзлэг хийдэг
- Нарны хэт ягаан туяанаас хамгаалдаг





Цаашид хийгдэх ажил

Түүх соёлын
дурсгалт зүйлийг
зориулалтын тоног
төхөөрөмж бүхий
олон улсын
стандартад
шаардлагад
нийцсэн
хадгалалтын
орчинг бүрдүүлнэ.

Хадгалалтын найдвартай орчинг бүрдүүлэх

- -Хүндрүүлэгчтэй сейф /нууцлалын өндөр зэрэглэлийн цоож, кодтой, дохиололжуулсан г.м
- -Хадгалах орчин, өрөө тасалгаа нь аюулгүй, нууцлалын байдлыг бүрэн хангасан